



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
БАЙНГЫН ХОРОО

14201 Улаанбаатар хот, Төрмөн ордон  
Сүхбаатарын талбай 8, Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreatkhural@parliament.mn  
http://www.parliament.mn

2023.10.10 № УИХ-04/7880

таний \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАРТ

Бүгд Найрамдах Узбекистан Улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулах тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, хуралдааны тэмдэглэлийг тус тус хүргүүлж байна.

Хавсралт 2 хуудастай.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ,  
ГАДААД БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА

Б.ЭНХ-АМГАЛАН



2023000725



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ  
ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 10 сарын 10 өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хуралдааны тэмдэглэл:

**ХЭЛЭЛЦСЭН нь:**

Бүгд Найрамдах Узбекистан Улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулах тухай асуудлыг зөвшилцөх.

**ШИЙДВЭРЛЭСЭН нь:**

Бүгд Найрамдах Узбекистан Улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулах тухай асуудлыг дэмжив.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД  
БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Б.ЭНХ-АМГАЛАН

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД  
БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРОО ХАРИУЦСАН РЕФЕРЕНТ

Б.ГАНДИЙМАА

**БҮГД НАЙРАМДАХ УЗБЕКИСТАН УЛСЫН НИЙСЛЭЛ ТАШКЕНТ ХОТОД  
МОНГОЛ УЛСЫН ЭЛЧИН САЙДЫН ЯАМ НЭЭН АЖИЛЛУУЛАХ ТУХАЙ  
АСУУДЛЫГ ЗӨВШИЛЦСӨН ТАЛААРХ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД  
БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2023 оны 10 дугаар  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 03-ны өдөр Улсын Их Хуралд зөвшилцөхөөр ирүүлсэн Бүгд Найрамдах Узбекистан Улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулах тухай асуудлыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн дэмжиж байгаагаа илэрхийлээд, Бүгд Найрамдах Узбекистан Улс нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн улс мөн эсэхийг тодруулаад, цаашид адил төстэй асуудлыг хэлэлцүүлэх танилцуулгадаа тухайн улсын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг өгдөг байх, Хамтын нөхөрлөлийн болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн улс орнуудтай харилцаа, хамтын ажиллагаагаа улам идэвхжүүлж, өргөжүүлэх нь Монгол Улсын язгуур эрх ашиг, үндэсний аюулгүй байдлыг сахин хамгаалахад чухал ач холбогдолтой тул Гадаад харилцааны яам бусад улс орнуудтай Дипломат төлөөлөгчийн газраа нээх талаар харилцан идэвхтэй ажиллах, дэлхийн улс орнууд геополитикийн зөрчилдөөнтэй байгаа энэ үед манай улсын баримтлах байр суурийг илүү тодорхой болгох, нээлттэй олон тулгуурт бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай талаар үг хэлсэн.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан манай улс Бүгд Найрамдах Узбекистан Улстай 10,4 сая ам.долларын экспорт, импортын гадаад худалдааны эргэлттэй байгааг цаашид өсгөн нэмэгдүүлэх, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн чиглэлээр тухайн бүс нутагтай хамтарч ажиллах, харилцааг өргөжүүлэх, гадаад худалдааг нэмэгдүүлэх, гадаад харилцааг эдийн засагжуулах тал дээр илүү түлхүү анхаарах, Гадаад харилцааны яам Монгол Улсаас гадаад улсад ачаалал ихтэй ажиллаж байгаа элчин сайдын яамдын ажилтнуудын цалин хөлсийг нэмэгдүүлэх шаардлагатай байгааг онцлоод, Дундад Азийг чиглэсэн дундын коридор гэж нэрлээд байгаа Бүгд Найрамдах Турк Улс, Бүгд Найрамдах Азербайжан Улс, Бүгд Найрамдах Казахстан Улсыг дамнасан торгоны замын урсгалыг манай улс тээвэр, гадаад худалдааны хувьд болон дамжин өнгөрүүлэх тээврийн хувьд ашигтай байлгах талаар онцгой анхаарах, энэ дундын коридорын чиглэл нь манай улсад өндөр ач холбогдолтой болох талаар үг хэлсэн болно.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Бүгд Найрамдах Узбекистан Улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулах тухай асуудлыг дэмжсэн болно.

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД  
БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**



**Б.ЭНХ-АМГАЛАН**